НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/394/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н.Баттогоо<br>Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn<br>Аудитор: Т.Мөнхцацрал<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhtsatsralt@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 247

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАДАМХАНД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 180.8 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 17.0 сая төгрөг, нийт 197.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2025 оны А/588 дугаар захирамжаар 148 байгууллага, 700 гаруй багш ажилтан, сурагч нарын "Амжилтын эзэн" арга хэмжээнд нийт 94.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\...\2026.02.25 Дүгнэлт-1.docx

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2025\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - -.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 5,350,451.00 | 3,193,080.00 |
| 33 | АВЛАГА | | 76,001.02 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 17,025.51 | - |
| 33500 | Бусад авлага | | 58,975.51 | - |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | 58,975.51 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | | 5,274,449.98 | 3,193,080.00 |
| 35400 | Хангамжийн материал | | 5,274,449.98 | 3,193,080.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 40,000.00 | 155,080.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 190,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 5,044,449.98 | 3,038,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1 | 75,505,457.74 | 64,600,593.66 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 75,505,457.74 | 64,600,593.66 |
| 39200 | Биет хөрөнгө | | 75,505,457.74 | 64,600,593.66 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 87,055,545.00 | 72,376,545.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (26,459,788.84) | (20,967,016.09) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 22,058,298.00 | 17,432,059.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (7,148,596.42) | (4,240,994.85) |
| 39301 | Программ хангамж | | 935,000.00 | 935,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (935,000.00) | (935,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 2 | 80,855,908.74 | 67,793,673.66 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 80,855,908.74 | 67,793,673.66 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 80,855,908.74 | 67,793,673.66 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 13,303,419.32 | 13,303,419.32 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | 13,303,419.32 | 13,303,419.32 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 67,552,489.42 | 54,490,254.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 144,034,325.56 | 67,552,489.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (76,481,836.14) | (13,062,235.08) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3 | 80,855,908.74 | 67,793,673.66 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 4 | 3,066,982,045.00 | 549,265,109.60 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 2,559,920,245.00 | 549,265,109.60 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 2,559,920,245.00 | 4,826,309.60 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 31,534,245.00 | 4,826,309.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 2,528,386,000.00 | - |
| 122 | Тусламжийн орлого | | - | 544,438,800.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | | - | 544,438,800.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | | - | 346,564,600.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | - | 346,564,600.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | - | 197,874,200.00 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | - | 197,874,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5 | 507,061,800.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 300,401,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 300,401,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 206,660,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 206,660,000.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | | 523,188,740.49 | 562,327,344.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 523,188,740.49 | 562,327,344.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 509,678,538.61 | 449,423,990.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 240,461,635.67 | 279,580,361.01 |
| 210101 | Үндсэн цалин | | 128,963,457.88 | 148,679,470.99 |
| 210102 | Нэмэгдэл | | 35,032,841.71 | 50,664,221.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 34,863,951.36 | 60,819,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 16,782,890.62 | 19,417,668.32 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 24,818,494.10 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 29,288,362.45 | 34,886,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | | 19,829,840.26 | 23,722,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | | 2,291,423.44 | 2,790,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | | 1,254,240.53 | 1,395,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | | 1,145,711.73 | 1,395,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | | 4,767,146.49 | 5,581,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 9,654,160.00 | 5,465,755.31 |
| 210401 | Бичиг хэрэг | | 8,241,060.00 | 1,604,706.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 246,100.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 448,800.00 | 502,099.33 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 221,700.00 | 824,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 496,500.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | - | 2,534,449.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 230,274,380.49 | 129,491,873.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 186,315,000.00 | 91,016,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 21,612,000.00 | 22,744,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 22,347,380.49 | 15,731,173.68 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6 | 13,510,201.88 | 112,903,354.68 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | - | 26,500,354.68 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | - | 26,500,354.68 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 26,500,354.68 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 26,500,354.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 6,950,000.00 | 86,403,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 5,000,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 1,950,000.00 | 86,403,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 6,560,201.88 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,560,201.88 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | | (73,449,279.83) | (13,062,235.08) |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 3,032,556.31 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 3,032,556.31 | - |
| VII | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | | (3,032,556.31) | - |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | | (76,481,836.14) | (13,062,235.08) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 507,061,800.00 | 544,438,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 544,438,800.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 544,438,800.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 544,438,800.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 346,564,600.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 346,564,600.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 197,874,200.00 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 197,874,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 507,061,800.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 300,401,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 300,401,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 206,660,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 206,660,000.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 496,364,300.00 | 544,438,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 496,364,300.00 | 544,438,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 482,854,098.12 | 431,835,445.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 240,461,635.67 | 279,504,359.99 |
| 210101 | Үндсэн цалин | 129,663,457.88 | 148,603,469.97 |
| 210102 | Нэмэгдэл | 35,032,841.71 | 50,664,221.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,863,951.36 | 60,819,000.00 |
| 210104 | Урамшуулал | 16,782,890.62 | 19,417,668.32 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 24,118,494.10 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,288,362.45 | 34,886,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 19,634,559.59 | 23,722,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 2,268,989.80 | 2,790,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 1,243,024.21 | 1,395,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 1,134,495.41 | 1,395,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 5,007,293.44 | 5,581,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,659,600.00 | 3,101,885.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,555,000.00 | 1,904,786.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 190,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 504,900.00 | 502,099.33 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,409,700.00 | 695,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 770,000.00 | 528,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 770,000.00 | 528,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 208,674,500.00 | 113,815,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 185,931,000.00 | 91,071,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,743,500.00 | 22,744,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,510,201.88 | 112,603,354.68 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 26,500,354.68 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 26,500,354.68 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 26,500,354.68 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 26,500,354.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,950,000.00 | 86,103,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,000,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,950,000.00 | 86,103,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,560,201.88 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,560,201.88 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 10,697,500.00 | - |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 10,697,500.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,697,500.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10,697,500.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,697,500.00 | - |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (10,697,500.00) | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 13,303,419.32 | - | 144,034,325.56 | 157,337,744.88 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,303,419.32 | - | 144,034,325.56 | 157,337,744.88 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | (76,481,836.14) | (76,481,836.14) |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 13,303,419.32 | - | 67,552,489.42 | 80,855,908.74 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 13,303,419.32 | - | 67,552,489.42 | 80,855,908.74 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 13,303,419.32 | - | 67,552,489.42 | 80,855,908.74 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (13,062,235.08) | (13,062,235.08) |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 13,303,419.32 | - | 54,490,254.34 | 67,793,673.66 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 12 | Татварын бус орлого | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 122 | Тусламжийн орлого | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 346,564,600.00 | 320,064,245.32 | 26,500,354.68 | 92.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 280,280,100.00 | 279,504,359.99 | 775,740.01 | 99.7 |
| 210101 | Үндсэн цалин | 165,237,600.00 | 148,603,469.97 | 16,634,130.03 | 89.9 |
| 210102 | Нэмэгдэл | 70,311,200.00 | 50,664,221.70 | 19,646,978.30 | 72.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,160,000.00 | 60,819,000.00 | (34,659,000.00) | 232.4 |
| 210104 | Урамшуулал | 18,571,300.00 | 19,417,668.32 | (846,368.32) | 104.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,886,000.00 | 34,886,000.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,722,500.00 | 23,722,500.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,790,900.00 | 2,790,900.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,395,400.00 | 1,395,400.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,395,400.00 | 1,395,400.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,581,800.00 | 5,581,800.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,022,700.00 | - | 6,022,700.00 | - |
| 210304 | Байрны түрээс | 6,022,700.00 | - | 6,022,700.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,745,200.00 | 3,101,885.33 | 10,643,314.67 | 22.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,990,700.00 | 1,904,786.00 | 1,085,914.00 | 63.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,517,800.00 | 502,099.33 | 4,015,700.67 | 11.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,613,200.00 | - | 1,613,200.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,623,500.00 | 695,000.00 | 3,928,500.00 | 15.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 528,000.00 | 528,000.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 528,000.00 | 528,000.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,142,800.00 | - | 1,142,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,142,800.00 | - | 1,142,800.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,959,800.00 | 2,044,000.00 | 7,915,800.00 | 20.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,959,800.00 | 2,044,000.00 | 7,915,800.00 | 20.5 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 12 | 10.00 | 2 | 82.3 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 9.00 | 2 | 82.3 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 197,874,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 197,874,200.00 |
| 122 | Тусламжийн орлого | 197,874,200.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 197,874,200.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 197,874,200.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 197,874,200.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 197,874,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 197,874,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 111,771,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,771,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,071,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,700,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 86,103,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 86,103,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 86,103,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,250.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 25,550.0 мянган төгрөгийн албан шаардлага, 6,700.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 32,250.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нэмэлт санхүүжилтийн данснаас хөтлөгч, урлагын хөтөлбөр, зураг даруулах булан зэрэг зардлыг гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан байна. | 1 | 25,500.0 | | | 1 | 25,500.0 | | | | | | |
| Сургалтад оролцсон явц, чанар, үр дүнгийн талаар танилцуулсан гүйцэтгэлийн тайлан, илтгэх хуудсыг хөтлөөгүй байна | 1 | 6,700.0 | | | | | 1 | 6,700.0 | | | | |
| **Дүн** | **2** | **32,250.0** | | | **1** | **25,500.0** | **1** | **6,700.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн данстай холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 гүйлгээ , зардлын 6 гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 11 шийдвэрийг хугацаа хоцроож, 318,167.8 мянган төгрөгийн орлогын 11 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 44,403.2 мянган төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1 | 362,571.0 | | | 1 | 362,571.0 | | | | | | |
| **Дүн** | **1** | **362,571.0** | | | **1** | **362,571.0** | | | | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 87/А0271247 Улаанбаатар хот

НТАГ-2026/394/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн данснаас хөтлөгч, урлагийн хөтөлбөр, зураг даруулах булан зэрэгт 25,550,000.0 (хорин таван сая таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйл 16.5.2-т батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагч байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; ", гэж заасныг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.6* *"Төсвийг зориулалт бусаар зарцуулсан"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Б.Бадамханд, нягтлан бодогч М.Цэнгэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Т.МӨНХЦАЦРАЛ

1426090145

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 84/А0212 Улаанбаатар хот

НТАГ-2026/394/НА СТА-ТШ3

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим цэсэнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 362,571,000.00 (гурван зуун жаран хоёр сая таван зуун далан нэгэн мянга) төгрөгийн орлогын 11 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14 шийдвэрийг мэдээлээгүй, 27 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4-д *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ."* 6.4.5-д *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"* 6.4.8-д *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;"* гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Б.Бадамханд, нягтлан бодогч М.Цэнгэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Т.МӨНХЦАЦРАЛ

1426090137